

Гэр бүлийг бүртгэх байгууллага

1926-10-15-анд Засгийн газрын эрхлэх товчооны хурлын тогтоолын 3-р зүйлээр “ эр,эм бололцохоор санаа тохирч батлуулахыг хүсч мэдүүлэх өргөдөл бичиж өөрсдийн гарын үсгийг тавьж батлан мэдүүллээс зохих ба мөн харьяат, хотын захиргааны газраас ёсоор болгож баталсан тухайн хариуг зохиогдох бичиг хуудас тушааж хос өдрийн бат баримт болгон ардын эрхт чөлөөг бадруулан явуул баас зохих учрыг хойшид тушааж гүйцэтгүүлэхээр тогтов” гэжээ.

1976-5-9-энд ЗХУ-аас Монголд бэлэг болгон барьж өгсөн Улаанбаатар хот дахь гэрлэх ёслолын ордонг Монголд хүлээлгэн өгөх Засгийн газрын бэлгийн актант ЗХУ-ын талаас Элчин сайд Смирнов, Монголын талаас Сайд нарын Зөвлөлийн 1-р орлогч дарга Майдар нар гарын үсэг зуржээ.

1976-6-12-онд БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойн баяраар ЗХУКН-ын Төв хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И.Брежнев манай эх оронд найрсаг айлчлах үеэрээ Монголын ард түмэнд гэрлэх ёслолын ор-донг бэлэглэсэн билээ. Энэ тус ордонг барьж байгуулсан зөвлөлтийн барилгын хоёрдугаар Триестийн дарга В.В Шорриков баяр хүргэн үг хэлж, гэрлэх ёслолын ордны түлхүүрийг Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга О.Цэндэд гардууллаа.

Монголын ард түмний аз Жаргалант амьдралын нэгэн бэлэг тэмдэг болон сүндэрлэсэн энэ сайхан ордонд ариун гэр бүл болох анхны ёслолыг Сэлэнгэ аймгийн Шаамрын тэжээлийн аж ахуйн траектор Л.Жаргалсайхан, Л.Тунгалаг нарын хэдэн залуу хос хийлээ.Л. Жаргалсайхан, Д. Тунгалаг нарыг БНМАУ-ын иргэний гэр бүлийн баталгаа хүлээн авсны дараа нам засгийн удирдагчид баяр талархал дэвшүүлж, МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал эцэг ёсны ариун сургаал хайрлан, аз жаргалыг ерөөж бэлэг дурсгал өглөө.